

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Ягаан-цээнэ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Дорнод аймаг

2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК

Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг

Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл.....	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэл	11
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн.....	13
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	14
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.03.16 № 347

танай _____-ны № _____-т

ХЭРЛЭН СУМЫН ЯГААН-ЦЭЭНЭ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ч.АЗЗАЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэрлэн сумын “Ягаан-цээнэ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад олгодог орон нутгийн нэмэгдлийг ажиллагсдад олгосон, батлагдсан төсвийг 526.6 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нийт 113.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

2126050171

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>288,358,563.55</u>	<u>235,161,668.27</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,330,994.81	48,584,211.31
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,330,994.51	48,584,211.31
3121	Төгрөг	1,330,994.51	48,584,211.31
31213	Арилжааны банк дахь харилцах	1,330,994.51	48,584,211.31
33	АВЛАГА	127,853,177.99	16,247,889.30
33401	Дансны авлага /ТӨҮГ/	127,853,177.99	16,247,889.30
35	БАРАА МАТЕРИАЛ	159,174,390.75	170,329,567.66
351	Түүхий эд материал	31,312,876.68	29,404,695.60
35110	Тусгай зориулалттай материал	31,312,876.68	29,404,695.60
35300	Бэлэн бүтээгдэхүүн	199,000.00	3,176,408.00
354	Хангамжийн материал	127,662,514.07	137,748,464.06
35410	Бичиг хэргийн материал	660,000.00	1,125,000.00
35420	Аж ахуйн материал	127,002,514.07	136,623,464.06
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>433,743,585.24</u>	<u>478,645,413.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	433,743,585.24	478,645,413.94
391	Газар	30,625,000.00	30,625,000.00
392	Биет хөрөнгө	399,364,051.91	444,654,280.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	194,741,881.56	194,741,881.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,701,437.04)	(36,938,692.63)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,100,000.00	41,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,010,666.67)	(26,730,666.67)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	285,425,842.76	371,111,742.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(117,479,442.67)	(155,303,584.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,643,005.00	87,349,605.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,355,131.04)	(30,676,005.20)
39301	Програм хангамж	445,867.00	445,867.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(445,867.00)	(445,867.00)
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	3,754,533.33	3,366,133.33
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	3,884,000.00	3,884,000.00
39402	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/	(129,466.67)	(517,866.67)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>722,102,148.79</u>	<u>713,807,082.21</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>722,102,148.79</u>	<u>713,807,082.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	722,102,148.79	713,807,082.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	213,288,191.80	213,288,191.80
51101	Өмч: - төрийн	213,288,191.80	213,288,191.80
512	Хуримтлагдсан үр дүн	408,128,371.43	399,833,304.85
51210	Өмнөх үеийн үр дүн	408,128,371.43	408,128,371.43
51220	Тайлант үеийн үр дүн	-	(8,295,066.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,685,585.56	100,685,585.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>722,102,148.78</u>	<u>713,807,082.21</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,468,510,402.39	1,551,726,524.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	132,612,997.43	1,551,726,524.58
120	Нийтлэг татварын бус орлого	132,612,997.43	1,551,726,524.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,384,157,641.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,384,157,641.90
120009	Бусад орлого	132,612,997.43	167,568,882.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,335,897,404.96	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,335,897,404.96	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,335,897,404.96	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,395,999,063.79	1,560,021,591.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,395,999,063.79	1,560,021,591.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,395,999,063.79	1,560,021,591.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	765,214,982.00	846,428,087.00
210101	Үндсэн цалин	765,214,982.00	846,428,087.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,775,922.45	92,255,713.97
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	92,255,713.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,677,244.68	28,066,066.56
210301	Гэрэл, цахилгаан	19,392,911.68	24,536,396.56
210304	Байрны түрээс	2,284,333.00	3,529,670.00
2104	Хангамж, бараа материалын зардал	357,334,786.25	382,484,255.79
210401	Бичиг хэрэг	21,408,160.00	22,698,662.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,168,822.87	3,373,117.33
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	45,549,390.60	60,228,219.38
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	3,350,000.00	3,479,200.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	283,858,412.78	292,705,057.08
2107	Томилолт, зочны зардал	8,318,728.00	7,216,696.00
210702	Дотоод албан томилолт	8,318,728.00	7,216,696.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	963,053.00	1,004,763.00
210803	Даатгалын үйлчилгээ	634,250.00	649,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,688.00	52,688.00
210807	Газрын төлбөр	194,415.00	194,415.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	81,700.00	108,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,714,347.41	202,566,008.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,814,027.60	116,250,857.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,568,400.00	6,816,480.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,331,919.81	79,498,671.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	72,511,338.60	(8,295,066.58)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	72,511,338.60	(8,295,066.58)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,153,420,809.15</u>	<u>1,367,527,314.78</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,389,610.25	42,770,712.58
120	Нийтлэг татварын бус орлого	2,389,610.25	42,770,712.58
120009	Бусад орлого	2,389,610.25	42,770,712.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,151,031,198.90	1,324,756,602.20
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,151,031,198.90	1,324,756,602.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,151,031,198.90	1,324,756,602.20
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,228,169,876.25</u>	<u>1,428,541,159.67</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,228,169,876.25	1,428,541,159.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,228,169,876.25	1,428,541,159.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,254,918.40	629,804,603.15
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	570,254,918.40	629,804,603.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,903,603.93	174,213,718.01
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	167,903,603.93	174,213,718.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,194,669.59	153,676,610.44
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	64,194,669.59	153,676,610.44
2104	Хангамж, бараа материалын зардал	359,306,210.18	398,399,212.60
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	3,380,000.00	3,479,200.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	355,926,210.18	394,920,012.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,510,474.15	72,447,015.47
210803	Даатгалын үйлчилгээ	634,250.00	-
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	65,876,224.15	72,447,015.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(74,749,067.10)</u>	<u>(61,013,844.89)</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	116,346,491.07	178,496,837.49
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	116,346,491.07	178,496,837.49
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	56,406,346.00	70,229,775.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,406,346.00	70,229,775.00
2200	Дотоод эх үүсвэрээр	56,406,346.00	70,229,775.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	56,406,346.00	70,229,775.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>59,940,145.07</u>	<u>108,267,062.49</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(14,808,922.03)	47,253,217.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,139,916.84	1,330,994.81
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,330,994.81	48,584,211.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	408,128,371.43	722,102,148.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	408,128,371.43	722,102,148.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	408,128,371.43	722,102,148.79
Тайлант үеийн үр дүн	-	-	-8,295,066.58	-8,295,066.58
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	399,833,304.85	713,807,082.21

2.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Дүн			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бусад орлого	132,613.00		167,568.88	34,955.89	
Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих орлого	1,335,897.40	1,033,365.70	1,384,157.64	350,791.94	133.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГЫН ДҮН	1,468,510.40	1,033,365.70	1,551,726.52	518,360.82	150.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	765,214.98	714,813.00	846,428.09	131,615.09	118.4
АО-оос НД-шимтгэлд төлөх зардал	90,775.92	89,351.60	92,255.71	2,904.11	103.3
Байр ашиглалттай холбоотой зардал	19,392.91	15,480.00	24,536.40	9,056.40	158.5
Хангамж бараа материалын зардал	27,926.98	36,172.50	29,550.98	-6,621.52	81.7
Нормативт зардал	283,858.41	92,199.80	292,705.06	200,505.26	317.5
Томилолт, зочны зардал	8,318.73	3,600	7,217	3,616.70	200.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	551.99	4,025.20	1,004.76	-3,020.44	25.0
Бараа үйлчилгээний бусад зардал	72,415.99	50,389.00	176,479.08	126,090.08	350.2
Бусад зардал	127,543.14	27,334.60	89,844.82	62,510.22	328.7
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	1,395,999.06	1,033,365.70	1,560,021.59	526,655.89	151.0
НИЙТ АШИГ/АЛДАГДАЛ	72,511.34		-8,295.06		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31.8 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан 31.8 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансны бүртгэлээс үндсэн хөрөнгө данс руу бүртгүүлж залруулав. Энэ

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 108.8 сая төгрөгийн 10 зөрчил² илэрснээс, 1.6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 107.2 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 108,821.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 91,364.6 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Томилолтын зардалтай давхардуулан хоолны хөнгөлөлтийг 240.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5-т “... ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Эрүүл мэндийн сайдын 2017.01.14-ний өдрийн А/04 тушаалаар баталсан Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 1.2-т “Төв нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, **бусад холбогдох хууль тогтоомж**, Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт болон энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.2.3-т “хоолны зардал” гэж заасныг зөрчсөн байна.
2. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 2022.05.16-ны өдрийн шийтгэх тогтоолын торгууль 1,000.0 мянган төгрөгийг байгууллагын данснаас төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”- гэж заасныг зөрчсөн байна.
3. “Дорнын талын өргөө” ХХК-тай өрөө түрээслэх гэрээг 3,200.0 мянган төгрөг буюу сарын 266.6 мянган төгрөг төлөхөөр байгуулсан. Тайлант онд 3,529.6 мянган төгрөгийг шилжүүлж 329.6 мянган төгрөгийн илүү зардал гаргасан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 16.5.6-т “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмын 4.1.5-д “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийн үүрэгт “Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх”- гэж заасныг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

1. Гэрээт нягтлан бодогчид ээлжийн амралтын олговрыг давхардуулан 2,412.2 мянган төгрөг олгосон байна. Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.6-т “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”, 19.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ”, Хөдөлмөрийн тухай хуулийн 57.3-т “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84.4-т “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна”, МУ-ын стандарт 5292:2017-гийн 7.13-т “ Үйл ажиллагааны ачаалал, хүчин чадлаас хамааран 2-3 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дунд орон тоогоор нэг нягтлан бодогч ажиллана ” - гэж заасантай нийцэхгүй байна.
2. Гэрээт ажиллагсад үр дүнгийн урамшуулалд 9,440.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3-т “Удирдах эрх бүхий гишүүд олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хариуцна”, 5-д “ Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийн болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд бусад гишүүд хяналт тавина, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нөхөрлөлийн дотоод журмын 1.8.8-д “Шагналд зөвхөн байгууллагын үндсэн ажилтныг нэр дэвшүүлэх ба түр ажилтан болон дадлагажигч ажилтан шагнал урамшуулал, нийгмийн халамжид хамрагдахгүй”- гэж заасантай нийцэхгүй байна.
3. Эмийн зардлын батлагдсан төсөв нь 92,199.8 мянган төгрөг бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4-т “ Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, ТБОНӨХБАШХА тухай хуулийн 10.3, ЗГ-ын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоохдоо “шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээг 20.0 сая төгрөг байх” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Өөрийн байранд боломжит талбай байхад үр ашиггүй зардал гарган түрээсийн байрны төлбөрт 3,200.0 мянган төгрөг зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”- гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.
5. Тайлант онд батлагдсан төсөв 1,033,365.7 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,560,021.6 мянган төгрөгийг зарцуулж, 526,655.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийг 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5.-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.9.-т “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох”- гэж заасантай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЭМТ-ийн ажилтанд сургалтын төлбөрийн дэмжлэг олгохдоо анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж олгоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтнаас дэмжлэг хүссэн хүсэлт, суралцагч хүүхдийн сургуульд сурч байгааг тодорхойлсон тодорхойлолт, сургалтын төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн дэмжлэг олгох шийдвэр гаргах, дотоод хяналтыг сайжруулах.

2. Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого, баримтжуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг баримтжуулж, эд хариуцагч бүрээр бүртгэлийг хөтлөөгүй, ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын чанарыг тодорхойлоогүй, актлах болох хасах бараа материал үндсэн хөрөнгийг нэг бүрчлэн баримтжуулж тоолоогүй, журналын хөлийн дүнгээр нэгтгэсэн жагсаалтыг хавсаргаж гарын үсэг зурсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70,71,72,73 дугаар зүйлд заасан бараа материал, эд хөрөнгийн тооллогыг бүрэн гүйцэд чанартай хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх, нотлох баримтыг хавсаргах, тооллогыг чанартай хийх.

“Ягаан-цээнэ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	31,587.0					1	31,587.0				
Дүн	1	31,587.0					1	31,587.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зардалд олгосон хоолны хөнгөлөлтийг цалин дээр нэмж давхардуулан олгосон	1	240.0	1	240.0								
Гэрээт нягтлан бодогчид ээлжийн амралтын олговрыг давхардуулан олгосон байна	1	2,412.2			1	2,412.2						
Эмийн зардлын батлагдсан төсөв нь 92,199,800 төгрөг бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна	1	92,199.8			1	92,199.8						
Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 2022.05.16-ны өдрийн шийтгэх тогтоолын торгуулийг байгууллагын данснаас төлсөн байна	1	1,000.0	1	1,000.0								
Гэрээт ажиллагсад урамшуулал олгосон байна	1	9,440.0			1	9,440.0						
Сургалтын төлбөрийн	1	-					1	-				

“Ягаан-цээнэ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

дэмжлэгийг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу, хангалтгүй												
Түрээсийн төлбөрийг илүү зарцуулсан	1	329.6	1	329.6								
Нягтлан бодогчид ажиллах ажлын байрыг өөрийн байр талбайд бэлтгэж өгөөгүй, түрээсийн 3,200.0 мянган төгрөгийн үр ашиггүй, гаргах шаардлагагүй зардал гаргасан байна	1	3,200.0			1	3,200.0						
Батлагдсан төсвийг гүйцэтгэлээр хэтрүүлэн зарцуулсан	1	-			1	-						
Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг чанартай хийгээгүй, эд хариуцагчийн картгүй, анхан шатны баримт хангалтгүй	1	-					1	-				
Дүн	10	108,821.5	3	1,569.6	5	107,252.0	2	-				